



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/277
танай _____-ны № _____-т
Аудитын гэрчилгээ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН "БАГАНУУР ТООСГО"
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ТАМИР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Багануур тоосго" ТӨААТҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Багануур тоосго" ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Багануур тоосго" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА



ШШГЕГ-ЫН “БАГАНУУР ТООСГО” ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер Н.Золзаяа
Утас: 260512

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512

“Ньюбаланс аудит” ХХК
Аудитор Д.Гэрэлчулуун

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. /САГ-2017/6/СТА-УТҮГ/

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн ШШГЕГ-аас гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ШШГЕГ-ын “Багануур тоосго”ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 28-наас 2017 оны 2 дугаар сарын 23-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалга гэрээний дагуу “Ньюбаланс Аудит” ХХК-ийн 2 дугаар багийн аудиторуд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 26-нд 1/32тоот албан бичгээр ирүүлсэн.

Үндэсний аудитын газар аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ -ын төвийн удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын захирагч нь Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд , түүний албан тушаалтны эрх, хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Энэ байгууллагын үйл ажиллагааны зорилго зорилт нь үйлдвэрийн газрын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, техник тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэчлэх, чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх.

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 27-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна.Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна.

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ нь “Ординат” ХХК-ийн “Unicus” нэртэй санхүүгийн програм ашиглаж байгаа бөгөөд уг програмыг бүрэн ашиглаж байна. Санхүүгийн тайланг програмаас бэлтгэн гаргаж байна.

Материаллаг байдлыг тооцсон тухайд:

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2016 оны 3-р улиралын нийт зардлын 2 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 2.3 сая төгрөг гэж тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны жилийн эцсийн нийт зардлын дүнгээр түвшинг шинэчлэн тогтоож 3.2 сая төгрөг болгож тооцсон. Учир нь нийт орлого, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгийн дүнгүүд өндөр байгаа тул нийт зардлаас тооцох нь зүйтэй гэж үзсэн.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төлөвлөгөөний орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ нь тайлант онд 368.0 сая төгрөгийн борлуулалтын орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 164.1 сая төгрөгийн борлуулалт хийж төлөвлөгөө 55.4%-иар буюу 203.9 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь тоосгоны борлуулалтыг төлөвлөгөөгөөр 1.300,0 мянган ширхэг тоосгыг нэгж үнийг 200 төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлээр 741.9 мянган ширхэг тоосгыг 130 төгрөгөөр борлуулалт хийгдэж 62.3 хувиар буюу 169.3 сая төгрөгийн борлуулалт тасарсан, хүнсний ногооны борлуулалтаас 75 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 53.6 сая төгрөгийн борлуулалт хийгдэж, төлөвлөгөө 21.4 сая төгрөгөөр тарсан боловч борлуулаагүй үлдэгдэл 69.2 тонн 29.9 сая төгрөгийн хүнсний ногоо байна. ШШГЕГ-т 42.5 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 3.0 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн нь энэ онд борлуулалт муутай байсантай холбоотой.

Шилэн дансны мэдээлэл

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн shilendans.gov.mn сайтад батлагдсан маягт хавсралтуудын дагуу төсөв, гүйцэтгэл, 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаа, бусад зарлагын гүйлгээний мэдээллийг сар бүр байршуулж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 48 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 27 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, хөрөнгө, бусад орлого, тээвэр шатахуун зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв. Үүнд:

1. Бараа материалыг зөв ангилан бүртгэсэн эсэхийг шалган үзэхэд ашиглалтанд байгаа аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 24.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2014 оны 12 сарын 23-ны 249 тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын 2.2 дугаар заалыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн дахин үнэлгээ хийх шаардлагатай 91.1 сая төгрөгийн хөрөнгө байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.2-д "Зах зээлийн үнэ, валютын ханшны өөрчлөлт зэргийг харгалзан эд хөрөнгийг дахин үнэлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно" гэж заасны дагуу дахин үнэлгээ хийлгэж, бүртгэх шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Цалингийн тооцооны журналын бичилтийг шалгахад цалингийн өглөг 1,254.4 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 103.7 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 1,150.7 мянган төгрөгөөр тус тус дутуу бүртгэж тайлагнасан байгаа нь Сангийн сайдын 2014 оны 12 сарын 23-ны 249 тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын 3.1-т заасан заалтыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад дээрх алдааг танилцуулж нягтлан бодох бүртгэлийн журналын бичилтэд залруулга хийлгэн аудитын хугацаанд санхүүгийн тайланг гаргуулав.

4. НӨАТ-ын тайлангийн борлуулалтыг санхүүгийн орлого үр дүнгийн борлуулалтын орлоготой тулган шалгахад 980.6 мянган төгрөгийн НӨАТ илүү ноогдуулсан байгаа нь НӨАТ-ын тухай хуулийн 7.1.1-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад дээрх алдааг танилцуулж нягтлан бодох бүртгэлийн журналын бичилтэд залруулга хийлгэн аудитын хугацаанд санхүүгийн тайланг гаргуулав.

5. Байгууллагын эзэмшилд байдаг 2 өрөө хоёр ширхэг орон сууцны зориулалттай байрыг ажилтан албан хаагчдаа түрээсээр суулгадаг. Орон сууцны түрээсийн 1.2 сая төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1-д заасан аккрузл сууриар бүртгэл хөтлөнө гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитаар нийт 2.2 сая төгрөгийн алдааг илэрснийг залруулсан тул залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

ШШГЕГ-ын “Багануур тоосго”ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал байхгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 120.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2.2 сая төгрөгийн алдааг залруулж, 118.2 сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ШШГЕГ-ЫН “БАГАНУУР ТООСГО”
ТӨААТҮГ-ЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

**Нэмэлт мэдээлэл
авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер
Н.Золзаяа
Утас: 260512

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512

“Ньюбаланс аудит” ХХК
Аудитор Д.Гэрэлчулуун

Тэргүүлэх ач холбогдол №1:

**Асуудал 1
Бараа материалын талаар хуудас 3**

**Асуудал 2
Үндсэн хөрөнгийн талаар хуудас 4**

**Асуудал 3
Орлогын бүртгэлийн талаар хуудас 5**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ШШГЕГ-ын “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ынажиглалт:

Бараа материалыг зөв ангилан бүртгэсэн эсэхийг шалган үзэхэд ашиглалтанд байгаа аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 24.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2014 оны 12 сарын 23-ны 249 тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг мөрдөөгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Сангийн сайдын 2014 оны 12 сарын 23-ны 249 тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг мөрдөж ажиллах.

Эрсдэл:

- СТОУС, холбогдох хууль, заавар, журамд нийцэхгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ынажиглалт:

Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн дахин үнэлгээ хийх шаардлагатай 91.1 сая төгрөгийн хөрөнгө байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.2-д "Зах зээлийн үнэ, валютын ханшны өөрчлөлт зэргийг харгалзан эд хөрөнгийг дахин үнэлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно" гэж заасны дагуу дахин үнэлгээ хийлгэж, бүртгэх шаардлагатай байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.2-д "Зах зээлийн үнэ, валютын ханшны өөрчлөлт зэргийг харгалзан эд хөрөнгийг дахин үнэлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно" гэж заасны дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн ирээдүйд өгөх эдийн засгийн үр өгөөжийг тооцон, мэргэжлийн байгууллагаар хөрөнгийн бодит үнэлгээг хийлгэж, холбогдох стандарт, заавар журмын дагуу шийдвэрлүүлэх.

Эрсдэл:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, заавар, журамд нийцэхгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ынажиглалт:

Байгууллагын эзэмшилд байдаг 2 өрөө хоёр ширхэг орон сууцны зориулалттай байрыг ажилтан албан хаагчдаа түрээсээр суулгадаг. Орон сууцны түрээсийн 1.2 сая төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1-д заасан аккрузал сууриар бүртгэл хөтлөнө гэсэн заалтыг зөрчсөн байна.

ҮАГ-ынзөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1-д заасан аккрузал сууриар бүртгэл хөтлөнө гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Эрсдэл:

- Түрээсийн орлогыг үнэн зөв бүртгэхгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Багануур тоосго" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 01-р сарын 01	2016 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	774,694.61	1,790,937.63
1.1.2	Дансны авлага	8,000,000.00	24,628,500.00
1.1.3	Ажилчдаас авах авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	133,538,380.10	136,829,697.06
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	142,313,074.71	163,249,134.69
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	26,648,733.06	32,813,488.60
1.2.2	Биет бус хөрөнгө	3,043,055.56	3,285,619.72
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	29,691,788.62	36,099,108.32
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	172,004,863.33	199,348,243.01
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	5,552,650.00	5,410,250.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	4,413,797.08	4,126,122.36
2.1.1.4	ЭМД-ийн өглөг	-	103,769.80
2.1.1.5	Бусад өглөг		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Системийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		10,017,124.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,966,447.08	19,657,266.16
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,966,447.08	19,657,266.16
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн		
2.3.2	- хувийн	192,291,669.83	192,291,669.83
2.3.3	Халаасны хувьцаа		
2.3.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(30,253,253.58)	(12,600,692.98)
2.3.8.1	Тайлангийн үеийн		(30,253,253.58)
2.3.8.2	Өмнөх үеийн	(30,253,253.58)	17,652,560.60
2.3.11	Эздийн өмчийн дүн	162,038,416.25	179,690,976.85
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	172,004,863.33	199,348,243.01

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Багануур тоосго" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 01-р сарын 01	2016 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		170,580,202.20
2	Борлуулалтын өртөг		117,062,598.82
3	Нийт ашиг (алдагдал)	-	53,517,603.38
4	Түрээсийн орлого		1,109,090.91
5	Хүүний орлого		52,535.81
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		45,106,028.10
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		7,396,277.77
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	16,969,479.77
19	Орлогын татварын зардал		297,448.41
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	16,672,031.36
21	ашиг (алдагдал)	-	
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	16,672,031.36
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	16,672,031.36
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Багануур тоосго" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	192,291,669.83						(30,253,253.58)	162,038,416.25
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							980,529.24	980,529.24
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							16,672,031.36	16,672,031.36
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	192,291,669.83	-	-	-	-	-	(12,600,692.98)	179,690,976.85

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Багануур тоосго" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31
(төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Эцсийн үлдэгдэл
ҮНДСЭН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	115,977,520.00	172,782,511.57
Бараа борлуулсан,үйлчилгээ үзүүлсний орлого	61,180,020.00	168,396,011.57
Эрхийн шимтгэл,хураамж,төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Татаас санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	54,797,500.00	4,386,500.00
Мөнгөн зарлагын дүн (-)	272,507,080.01	168,818,804.36
Ажиллагчдад төлсөн	70,439,621.83	71,864,294.51
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	379,406.80	292,903.68
Бараа материал худалдан авахад төлсөн	74,188,600.00	38,610,670.00
Ашиглалтын зардалд төлсөн	7,088,163.00	3,417,995.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	26,610,900.00	22,495,365.00
Татварын байгууллагад төлсөн	6,020,921.41	12,932,626.17
Даатгалын төлбөрт төлсөн	1,316,266.97	-
Бусад мөнгөн зарлага	86,463,200.00	19,204,950.00
Хүүний төлбөрт төлсөн		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(156,529,560.01)	3,963,707.21
Мөнгөн орлогын дүн (+)	-	52,535.81
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		52,535.81
Хүлээн авсан ногдол ашиг		
Улсын төсвийн хөрөнгө оруулалт		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР	-	52,535.81
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	125,216,842.50	-
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал		
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	118,764,000.00	
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Бусад	6,452,842.50	
Мөнгөн зарлагын дүн (-)	568,067,000.00	3,000,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	568,067,000.00	
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Бусад		3,000,000.00
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДЭН	(442,850,157.50)	(3,000,000.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(599,379,717.51)	1,016,243.02
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	600,154,412.12	774,694.61
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	774,694.61	1,790,937.63

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ШШГЕГ-ын "Багануур тоосго" ТӨААТҮГ

2016.01.01 - 2016.12.31
/мянган төгрөгөөр/

д/д	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				/+илүү, -дутуу/	Хувь
А. ОРЛОГО					
1	Борлуулалтын орлого-Тоосго	260,000.0	90,738.7	(169,261.3)	34.9%
3	Борлуулалтын орлого-Нүхтэй блок	25,000.0	8,737.9	(16,262.1)	35.0%
4	Борлуулалтын орлого-Захиалгат оёдол		151.4	151.4	
5	Борлуулалтын орлого-Мужаан	8,000.0	10,862.2	2,862.2	135.8%
6	Борлуулалтын орлого-Хүнсний ногоо	75,000.0	53,595.0	(21,405.0)	71.5%
	Үйл ажиллагааны орлогын дүн	368,000.0	164,085.2	(203,914.8)	44.6%
1	Үнэ төлбөргүй орлого- Ерөнхий газар		1,561.4	1,561.4	
2	Үнэ төлбөргүй орлого- Анги салбар		13,778.3	13,778.3	
3	Хүүгийн орлого		52.5	52.5	
4	Түрээсийн орлого		1,109.1	1,109.1	
5	ҮААБус орлого /Цайны газар/		6,495.0	6,495.0	
6	Бусад орлого				
	ОРЛОГЫН ДҮН	368,000.0	187,081.5	(180,918.5)	50.8%
1	Үндсэн болон нэмэгдэл цалин		30,108.9	30,108.9	
2	НДШ		912.5	912.5	
3	Хоол унааны хөнгөлөлт			-	
5	Бичиг хэргийн зардал			-	
6	Банкны шимтгэл		36.3	36.3	
7	Гэрэл цахилгааны зардал			-	
8	Түлш, халаалтын зардал			-	
9	Цэвэр, бохир усны зардал			-	
10	Тээвэр, шатахууны зардал		1,262.6	1,262.6	
11	Шуудан холбооны зардал			-	
12	Дотоод томилолтын зардал			-	
13	Гадаад томилолтын зардал		1,901.4		
14	Авто сэлбэг, хэрэгсэл		1,324.0	1,324.0	
15	Барилгын урсгал засвар		2,300.0	2,300.0	
16	Сав баглаа боодлын зардал		780.0	780.0	
17	Хөдөлмөр хамгаалал			-	
18	Биет хөрөнгийн элэгдлийн зардал		2,654.1	2,654.1	
19	Биет бус хөрөнгийн элэгдлийн зардал			-	
20	Дотоод сургалт			-	
21	Аудитын төлбөр		2,727.3	2,727.3	
22	Зар сурталчилгааны зардал		36.1	36.1	
23	Нөөц ашигласаны төлбөр		432.0	432.0	
24	Газрын татвар			-	
25	ҮХХ-ийн татвар		631.0	631.0	
28	Даатгал			-	
29	Үйлд.бусад зардал			-	
	ДҮН /А/	-	45,106.20	43,204.80	
Б. Үйл ажиллагааны бус зардал					
1	Ханив тцсламж буцалтгүй тэтгэмж		1,947.2	1,947.2	
2	Спортын арга хэмжээнд			-	
3	Ерөнхий газарт төвлөрүүлсэн		3,000.0	3,000.0	
4	Хүү торгууль хөнгөлөлтийн зардал			-	
5	Актлаж данснаас хассан бараа материал		2,969.3	2,969.3	
6	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз			-	
7	Бусад		382.5	382.5	
	ДҮН /Б/	-	8,299.00	8,299.00	
	ЗАРДЛЫН ДҮН	-	53,405.2	51,503.8	
В. Ажиллагсад бүгд					
1	Удирдах ажилтан	6	6	-	
		6	6	-	
				-	